



## ДОРНОД АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 70584203  
Цахим хаяг: Tuulai\_2008@yahoo.com

Аудитын менежер: Б.Дэлгэрмаа  
Утас: 70584203, 98999012  
Цахим хаяг:  
Delgermaa1967@yahoo.com

Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 93013453  
Цахим хаяг: Mandakh\_da@yahoo.com

**ТАБ-ын хаяг:** АЗДТГ-ын 2-р байр

**Байршил:** Хэрлэн сум

**Цахим хуудас:** [www.audit.dd.gov.mn](http://www.audit.dd.gov.mn)

### АУДИТЫН ТАЙЛАН

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## Нэг. Ерөнхий зүйл

### 1.1 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Төрийн тухай хуулийн 8.9.4, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 408 тоот тушаалын 1 дүгээр хавсралтыг үндэслэн аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ДОР-2015/143/СТА-ТЭЗ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Дорнод аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 1.2 Аудитын арга зүй

Аудит хийхэд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Дорнод аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 3-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Аймгийн Засаг даргын захирамжаар 2006 онд боловсруулан баталсан орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн программ нийцсэн байна.

Дорнод аймгийн Төрийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Дорнод аймгийн Төрийн сангийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

### **1.3 2014 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал**

Дорнод аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 01-нд Дорнод аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Дорнод аймгийн Аудитын газар аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 01-нээс 2015 оны 4 дүгээр сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 4 дүгээр сарын 16-нд Дорнод аймгийн Засаг даргад гардуулна.

Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ, ЗДНС, ОНХС, СХС, Орон нутгийн өмчийн алба, Байгаль орчны алба, Ахмадын хороо, Баян-Уул сумын сум дундын ойн анги, Зүүн бүсийн зөвлөл, Худалдан авах ажиллагааны алба, 14 сумын ИТХ, ЗДТГ, Багийн ажлын алба, Засаг даргын нөөц сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Боловсрол соёлын салбарын 60, Эрүүл мэндийн салбарын 10, Орон нутгийн өмчит үйлдвэрийн 19 газар, нийт 156 байгууллагын тайлан нэгтгэгдсэн. Үүнээс:

- ✓ Зөрчилгүй санал дүгнэлт 152,
- ✓ Хязгаарлалттай санал дүгнэлт 3,
  - Аймгийн ИТХ
  - Баяндун сумын орон нутгийн нэгтгэсэн тайлан
  - Баян-Уул сумын хүүхдийн цэцэрлэг

✓ Татгалзсан санал дүгнэлт

- Баяндун сумын Засаг даргын нөөц сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн тайлан хуулийн заасан хугацаанд тайланг хариуцсан аудиторт хүлээлгэж өгөөгүй тул дүгнэлт өгөхөөс татгалзсан болно.

## 1.4 Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсвийн байгууллагууд, тусгай шилжүүлгийн, ОНӨҮГ болон тусгай сангуудын хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн урьдчилсан дүгнэлттэй харьцуулахад зөрүү гараагүй.

## Хоёр.Санхүүгийн тайлангийн дансдын талаар

### 2.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

#### 2.1.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5147,6 сая төгрөгөөр тайлагнасан байна. Үүний орон нутгийн харилцахын үлдэгдэл 2506,5 сая төгрөг, тусгай зориулалтын сангийн харилцах 1065,3 сая төгрөг, төсөвт байгууллагын арилжааны банкинд дахь харилцах 981,8 сая төгрөг, Жижиг мөнгөн санд 15,5 сая төгрөг байна.

#### 2.1.2 Арилжааны банкин дахь харилцах дансны талаар

Арилжааны банкин дахь 981,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үлдэгдлийн ихэнх хувийг Дорнод НАА ХХК-ий 910,8 сая төгрөг эзлэж байна.

Байгууллагын нэрс	Мөнгөн дүн /сая.төг/
Дорнод НАА ХХК	910,8
Өрхийн эмнэлэгүүд	14,1
Гэрэл сэтгэмж ОНӨҮГ	0,87
Сумдын ОНӨҮГ	1,0
Сумдын Төрийн сангууд	12,6
Халамжийн сан	15,1
Чойбалсан хөгжил ОНОҮГ	1,6
Эмийн эргэлийн сан 13 сумын/	0,248
Хот тохижилт	1,7

### 2.2 Авлагын бүртгэл, тайлагнал

### **2.2.1 Авлагын бүтэц**

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар авлагын эхний үлдэгдэл 3438,4 сая төгрөг байснаас оны эцэст 4008,2 сая төгрөг болсон байна.

Нийт 4008,2 сая төгрөгийн авлагын хувь хүнээс авах авлага 3031,9 сая төгрөг, байгууллагаас авах авлага 855,9 сая төгрөг, хувийн хэвшил аж ахуйн нэгжээс авах авлага 114,2 сая төгрөг, ажиллагсадтай холбогдсон авлага 6,2 сая төгрөг байна.

Хувь хүнээс авах авлага өндөр байгаа нь Сум хөгжүүлэх сангаар иргэдэд олгосон зээлтэйгээр холбогдон 3270.6 сая төгрөгийн авлага үүссэн байна.

### **2.2.2 Авлагын үлдэгдэл тооцоо нийлэлтийн талаар**

2014 оны жилийн эцсээр сум хөгжүүлэх сангаар олгогдсон хугацаа хэтэрсэн үндсэн зээл, зээлийн хүүгийн төлөгдөөгүй 165.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хувь хүн, байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулалгүй 16.3 сая төгрөгийн авлагыг тусгасан байна.

Халх гол сумын Сум хөгжүүлэх сангийн 2011 онд олгосон үндсэн зээл, зээлийн хүү, алдангийн нийт 5.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй үлдэгдлийг Аймгийн МХГ-аас улсын орлого болгон МХГ-ын дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон нь "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 2.1.3-д заасан сангийн эх үүсвэр нь "иргэн, аж ахуйн нэгжид сангаас олгосон зээлийн хүүгийн орлого" байна, 3.2.4-д "эргэн төлөгдсөн зээл, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

## **2.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал**

### **2.3.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар**

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар бараа материалын эхний үлдэгдэл 4455,4 сая төгрөг байснаас оны эцэст 5414,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 21,5 хувиар өссөн байна.

Бараа материалын үлдэгдлийн өсөлтийг судлахад хангамжийн материал 628,8 сая төгрөг, мал амьтад 221,0 сая төгрөг, түүхий эд материал 109,2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь бараа материалын тайлан гаргаж, тооллого тооцоо хийлгүй жилийн эцсийн тайлан балансыг илэрхийлсэн.

### **2.3.2 Үнэ төлбөргүй авсан болон акталсан бараа материал**

Тайланд онд хандив тусламж, бусад эх үүсвэрээр авсан 1180,7 сая төгрөгийн бараа материалыг орлогодон, 98,9 сая төгрөгийн материалыг акталж устгасан байна.

## 2.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

### 2.4.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 106344,5 сая төгрөг байснаас оны эцэст 129815,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 22 хувиар өссөн байна.

Ангилал	Эхний үлдэгдэл /сая.төг/	Эцсийн үлдэгдэл /сая.төг/	Зөрүү /сая.төг/
Барилга байгууламж	71332,6	81082,7	9750,1
Тээврийн хэрэгсэл	3957,3	4843,7	886,4
Машин тоног төхөөрөмж	6232,0	7314,7	1082,7
Тавилга, эд хогшил	3576,2	5955,9	2379,7
Зам гүүрийн байгууламж	1308,4	1552,6	244,2
Түүх соёлын дурсгалт зүйлс	2168,9	2422,6	253,7
Бусад үндсэн хөрөнгө	9002,6	11105,9	2103,3
Дуусаагүй барилга байгууламж	8119,4	14102,7	5983,3
Биет бус хөрөнгө	378,5	430,7	52,2

Аймгийн ХХААГ-т бүртгэлтэй 6 ширхэг нэг бүр нь 44,1 сая төгрөгийн үнэ бүхий 264,7 сая төгрөгийн өртөгтэй мал ариутгал, халдваргүйжүүлэлтийн зөөврийн угаалгын ванн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд давхар тусгагдсан байна.

Чулуунхороот сумын ЗДТГ-ын конторын складны 0,2 сая төгрөгийн үнэтэй барилгыг буулган орон сууц болгон өөрчилж 6,0 сая төгрөгөөр үндсэн хөрөнгөнд давхар бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэж заасныг зөрчсөн байна.

Аймгийн ИТХ нь 2014 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллого, тооцоог хийлгүй балансыг тайлагнасан байна.

### 2.4.2 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

Тайлант үеийн элэгдлийг 170,0 сая төгрөгөөр дутуу тайлан балансад илэрхийлснийг аудитын явцад залруулсан.

### 2.4.3 2 Үнэ төлбөргүй авсан болон акталсан үндсэн хөрөнгө

Тайланд онд хандив тусламж, бусад эх үүсвэрээр авсан 10061,3 сая төгрөгийн барилга байгууламж, 929,5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1017,9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2293,7 сая төгрөгийн тавилга эд хогшил, 821,3 зам гүүр, 250,0 сая түүх соёлын дурсгалт зүйлс, 8527,6 дуусаагүй барилга, 2454,6 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг тайлагнан, 375,8 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

## **2.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал**

### **2.5.1 Өр төлбөрийн бүтцийн талаар**

Орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар эхний үлдэгдэл 3383,8 сая төгрөг байснаас оны эцэст 3607,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өр төлбөр 6,6 хувиар өссөн байна.

Нийт өглөгийн ихэнхи хувь 3268,4 сая төгрөг нь Дорнод НАА ХХК-ий Азийн хөгжлийн банк, МУ-ын ЗГ, АЗДТГ-ийн гурвалсан гэрээгээр орон нутгийн Хотуудын Нийтийн аж ахуйг хөгжүүлэх МОН1907 төслөөр олгогдсон зээл эзлэж байна.

### **2.5.2 Өр төлбөрийн дансны үлдэгдэл баталгаажуулалт, тооцоо нийлэлт**

Хувь хүн, байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулалгүй 8,3 сая төгрөгийн өглөгийг тусгасан байна.

## **2.6 Орлого, татаас санхүүжилтийн талаар**

### **2.6.1 Улсын төсвийн орлого**

### **2.6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт**

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 5904,8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэгт 26873,2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд 8379,2 сая төгрөг олгосон байна.

### **2.6.3 Өөрийн орлого**

Төсөвт байгууллагууд нь өөрийн орлогоор 205,0 сая төгрөгийн өөрийн орлого оруулсан байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн төсөвт байгууллага 111,6 сая төгрөг
- ✓ Төсвийн зориулалтат шилжүүлэг байгууллага 93,3 сая төгрөг

### **2.6.4 Татварын орлого**


Аймгийн нийт орлого ба тусламжийн төсвийн гүйцэтгэл 53942.1 сая төгрөг гарч үүнээс тусламжийн орлого буюу санхүүгийн дэмжлэг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн орлого 41059.9 сая төгрөгийг хасаж тооцоход аймгийн төсвийн нийт орлого 12882.2 сая төгрөг байна.



Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 11122.1 сая төгрөг, гүйцэтгэл 12882.2 сая төгрөг бөгөөд 15.8 хувиар буюу 1760.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын 90.0 хувийг татварын, 9.6 хувийг татварын бус, 0.4 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байна.

Графикаар харуулбал:



Төсвийн орлого давж биелэхэд улсын тэмдэгтийн хураамж 67.1 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 71.0 сая төгрөгөөр, Байгалийн нөөц ашигласны төлбөр 528.9 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 196.5 сая төгрөгөөр давж биелсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Төсвийн орлогын нэр төрлөөс түрээсийн орлого 1.3 сая төгрөгөөр, дуудлага худалдаа сонгон шалгаруулатын орлого 129.3 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 71.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогын бусад эх үүсвэрийн хувьд хувь хүний орлогын татварын буцаан олголтод 711.1 сая төгрөг олгосон нь өнгөрсөн оныхоос 141.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 5904.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд 8379.2 сая төгрөг олгосон байна.

Төсвийн орлогын бусад эх үүсвэрийн хувьд хувь хүний орлогын татварын буцаан олголтод 711,1 сая төгрөг олгосон байна.

## 2.7 Зарлагын талаар

### 2.7.1 Санхүүжилтийн зарцуулалт

Дорнод аймаг 2014 онд орон нутгийн төсөвт 28118.4 сая төгрөг, тусгай шилжүүлгийн байгууллагуудад 26873.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 28005.2 сая төгрөг, тусгай шилжүүлгийн байгууллагуудад 26775.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагын хувьд харилцахын үлдэгдлийг төвлөрүүлэн татаас шилжүүлэг дансанд бүртгэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулсан дүнгээр тайлагнасан байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 58758.5 сая төгрөгөөр батлагдсанаас 56000.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудын санхүүжилтэд 29133,4 сая төгрөг, орон нутгийн тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсөвт 26866.6 сая төгрөг зарцуулсан байна.

Өмнөх онд орон нутгийн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 46328.9 сая төгрөг байсан бол тайлант онд 56000.0 сая төгрөг болж 9671.1 сая төгрөгөөр буюу 17 хувиар өссөн байна.

Төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харууллаа. Үүнд:/сая. төгрөгөөр/

№	Нийт зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Хэтрэлт/ хэмнэлт	Гүйцэтгэлийн хувь	Эзлэх хувь
1	Ажиллагсадтай холбогдсон зардал	24,341.4	24,163.1	178.3	99.3	43.1
2	Бараа үйлчилгээний бусад зардал	11,836.2	11,552.9	283.3	97.6	20.6
3	Татаас ба урсгал шилжүүлэг	9,339.8	9,103.2	236.6	97.5	16.3
4	Хөрөнгийн зардал	13,241.1	11,180.8	2,060.3	84.4	20.0
<b>Нийт дүн</b>		<b>58,758.5</b>	<b>56,000.0</b>	<b>2,758.5</b>	<b>95.3</b>	<b>100.0</b>

Нийт зардлын 43 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 20 хувийг бараа үйлчилгээний зардал, 16 хувийг татаас ба урсгал шилжүүлэгийн зардал, 20 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Аймгийн ИТХ нь 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй тайлагнасан боловч "Шунхлай Говь" ХХК-д 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн тооцоо нийлсэн актаар өмнөх оны өр хэмээн 0.8 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-д суудалтай намуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн 42.5 сая төгрөгийн зарцуулалтын тайлан байхгүй байна.

Батлагдсан төсвөөс цалин, нийгмийн даатгалын шимтгэлд Чиг үүргийн давхардалтай албан хаагчдад 59.8 сая төгрөг зарцуулсан байна.

Дашбалбар сумын ЗДТГ Төрийн сангийн төлөөлөгчийн цалинг ТЗ-6-1 шатлалаар цалинжуулан 356'802 төгрөг 57 мөнгийг илүү олгосон байна

Төсвөөс хүүхдийн баярын бэлэг, дурсгалын зүйлд 1,4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хичээл үйлдвэрлэлийн зардлаар баталсан 5.9 сая төгрөгийг иргэдийн төлөөлөгчдийн хурлын хоолны зардалд зарцуулсан нь Засгийн газрын 147-р тогтоолын 7-д заасан “Хурал, сургалт, зөвлөгөөнийн давтамжийг багасгах, зайлшгүй тохиолдолд төлөөлөгчдийн тоог цөөн оновчтой богино хугацаанд хийхээр эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Халх гол сумын тайлангаар хувь хүний харилцах дансанд нийт 21.6 сая төгрөгийг шилжүүлсэн нь Сангийн сайдын 276-р тушаал Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмын заалтуудыг зөрчсөн байна.

Матад сумын Сум хөгжүүлэх сангаас гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаанд зориулан үндсэн хөрөнгө худалдан авсан 1.2 сая төгрөгийг байгаль орчны улсын байцаагч Ш.Өлзийдүүрэнд хүчин төгөлдөр бус баримтаар, бэлнээр олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д "... хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалт, Сангийн сайдын 2012 оны 12 тоот тушаалаар батлагдсан“ Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Матад сумын Сум хөгжүүлэх сангаас гэрэл, машин засвар, шатахуун, цалингийн зардалд нийт 8.2 сая төгрөгийн зардал гаргасан нь Засгийн газрын 2011 оны 134 тоот “Сум хөгжүүлэх сангийн журам”-ын 1.5-д “жижиг дунд үйлдвэр байгуулах ...зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулана” гэсэн заалтай нийцэхгүй байна.

Матад сумын ЗДТГ-ын дээврийн урсгал засварт 14,0 сая төгрөгийн бараа материал шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журамд заасан “Бараа ажил үйлчилгээ 10'0 саяаас дээш худалдан авалтын үед харьцуулалтын аргаар худалдан авах Дээд хязгаар тогтооно” гэснийг зөрчсөн байна.

## **2.7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт**

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь нэмэлт санхүүжилтийн дансаар 3392,0 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин зарцуулагдсан эм, вакцины зэрэг буцаан олгогдох 46,2 сая төгрөгийн орлогыг шууд зардал бичин өглөгөөр бүртгээгүй байна.

### **2.7.3 Тусгай шилжүүлгийн зарцуулалт**

Тусгай зориулалтын шилжүүлэгт 26873,2 сая төгрөг төлөвлөгдснөөс 26776,1 сая төгрөгийн зардлын гүйцэтгэл гарсан байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагын хувьд харилцахын үлдэгдлийг төвлөрүүлэн татаас шилжүүлэг дансанд бүртгэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулсан дүнгээр тайлагнасан байна.

### **2.7.4 Сангийн зарцуулалтын талаар:**

Аймгийн хэмжээнд тусгай зориулалтын сангуудын санхүүгийн тайлангаар 2014 оны жилийн эхэнд харилцах дансанд 659,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 4906,8 сая төгрөгийн дэмжлэгээр эх үүсвэр бүрдүүлэн 4067,0 сая төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж, харилцах дансандаа 1499,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн ЗДНС-аас гадаад дотоодын зочдод хүндэтгэл үзүүлэх зардалд 63.4 сая төгрөгийг зарцуулахдаа Засгийн газрын 1999 оны 198 тоот тогтоолоор батлагдсан "Хүндэтгэлийн зоог, хүлээн авалт хийх зардлын норматив", "Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"-д заасан нэг хүнд ногдох зардлын нормативыг баримтлаагүй нь "Төсвийн тухай" хуулийн 41.2.3 дахь "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалтыг зөрчсөн байна. Аймгийн ЗДНС-аас хүндэтгэлийн арга хэмжээнд хөрөнгө зарцуулахдаа төсвийг хэтрүүлэн төлөвлөх, гараар нэмэлт оруулж засварласан төсвөөр захирамж гаргах зэрэг зөрчлийг гаргасан нь дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

Аймгийн ЗДНС-аас Дорнод аймгийн Залуучуудын холбооны үйл ажиллагаанд олгосон дэмжлэгийн 0.9 сая төгрөгийн гүйцэтгэлийн баримт дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7 дахь "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Аймгийн ЗДНС нь нийт 38.9 сая төгрөгийг хөрөнгө худалдан авахад нь зориулж сумын төсөвт байгуулагуудад шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2012 оны 239 тоот тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 5 дугаар зүйлийн 15 дахь заалтай нийцэхгүй байна.

Аймгийн хөгжлийн сангаас, Аймгийн баяр наадам, Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулагдсан "Дорнод талын их хурд-2014" зүүн бүсийн хурдан морины уралдааны арга хэмжээнд Засаг даргын захирамжаар 59.3 сая төгрөгийг нэр заасан хандиваас илүү, Аймгийн баяр наадам, Засгийн газрын шийдвэрээр зохион

байгуулагдсан “Дорнод талын их хурд- 2014” зүүн бүсийн хурдан морины уралдааны арга хэмжээнд 101.5 сая төгрөгийг удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, Засаг даргын захирамжгүйгээр зарцуулсан нь Аймгийн хөгжлийн сангийн журмын 5.1.12 дахь “Аймгийн түүхт ой баяр наадам, бүсийн уралдаанд зориулан тодорхой нэр заан хандивласан байгууллага, аж ахуйн нэгж иргэдийн хандив, тусламжийг нэр заасан хандивын хэмжээгээр зарцуулах”, 6.1 дэх “Аливаа албан тушаалтан байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс сангийн зөвлөлийн шийдвэр, Засаг даргын захирамжгүйгээр бараа бүтээгдэхүүн авах, санхүүжүүлэх талаар тохиролцох хэрэгжүүлэхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Сум хөгжлийн сангийн журмын хөрөнгө бүрдүүлэх эх үүсвэрт заагдаагүй байгаль орчны барьцааны 10,2 сая төгрөгийг сум хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Баянтүмэн сум ОНӨҮГ байгуулж ОНХС-аас 8.3 сая төгрөгөөр цалинжуулсан нь ОНХС-ын журамын 4.2-д “тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх”, 60.3 “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Баяндун сумын Төрийн сангийн төлөөлөгч Р.Сүрэнжав нь Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, ЗДНС-ийн санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанаас хоцроон 03 дугаар сарын 23-нд Аудитын газарт ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх “Төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харъяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн тул санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Чулуунхороот сумын Сум хөгжүүлэх сангаас ЗД-ын 4/114 тоот захирамжаар СХС-гийн үйл ажиллагаатай холбогдолгүй ИТХ-ын төлөөлөгчдийн албан томилолт, сургалтын зардалд нийт 1,2 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 1.8. дахь “Сангаас олгох зээлийн хүүгийн орлогын 50 хүртэл хувийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулагдсан төсөл сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих ажлыг зохион байгуулах зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулж болно. Үлдэх хувийг сангаас олгох зээлийн эргэлтийн хөрөнгө болгож ашиглана. “гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

## **2.11 Хөрөнгө оруулалтын талаар:**

Оны эцсийн гүйцэтгэлээр 1381,8 сая төгрөгийн 33 төсөл арга хэмжээ хэрэгжиж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 89,2 хувь байна.

2014 онд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 167.0 сая төгрөгийн дараах 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

1. Авто замын болон явган замын хөдөлгөөнийг зохицуулах гэрлэн дохио, хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээ суурилуулахаар төлөвлөгдсөн 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын төсөвт өртөг нь уг ажлыг хийхэд хүрэлцэхгүй гэж үзсэн тул өртгийг нэмэгдүүлж 2015 оны төсөвт шилжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

2. Хэрлэн сумын 10-р багийн төвийн барилга 130.0 сая төсөвт өртөгтэй ажил зураг төсөвгүй гэсэн шалтгааны улмаас хэрэгжээгүй тул 2015 оны төсөвт шилжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

3. Баяндун сумын Яргай багийн эмчийн байрны тохижилт, тоног төхөөрөмжийн 7.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын нэр зориулалт өөрчилсөн тул санхүүжилтийг олгоогүй байна.

АЗДТГ нь Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Ланд крузер 200 маркын суудлын авто машиныг 159.9 сая төгрөгөөр худалдан авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2007 оны "Суудлын автомашины талаар авах арга хэмжээний тухай" 349 тоот тогтоолын 6 дахь заалт, 2014 оны "Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" 147 тоот тогтоолын 3.4 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Чойбалсан сум нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 50,0 сая төгрөгийг Засаг даргын нөөцийн сангийн Дансанд хувиарлаж төрийн сангийн төлөөлөгч зарцуулалтын эрхийг олгосон нь Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын 3.1. "Төсвийн санхүүжилт болон зарцуулалтын эрх нь тухайн байгууллагын батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт нийцсэн байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

## **Гурав: Аудитын дүнгийн талаар**

### **3.1 Тусгай шилжүүлгийн байгууллагын аудитын дүнгийн талаар**

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1527,7 сая зөрчил илэрч, 1356,3 сая төгрөгийг аудитлагдсан тайлангаар залруулж, 9,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 108,0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага тус тус хүргүүлсэн.

### **4.1 ОНӨҮГ-уудын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар**

ОНӨҮГ-уудын төсвийн гүйцэтгэлийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 42,8 сая төгрөгийн зөрчил илэрч, 14,1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 12,1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах болон хариуцлага тооцуулах 3 албан шаардлага бичигдсэн.

### **6.1 Орон нутгийн сан, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аймгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөцийн сан, Орон нутгийн хөгжлийн сан 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 236,6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 5 зөвлөмж өглөө.

## 7.1 ТӨҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар байхгүй

### 8.1 Бусад асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 81 ширхэг 99,9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон Монгол улсын төсвийн тухай хууль болон холбогдох зааврыг мөрдөж ажиллах, зөрчил дутагдлыг засч залруулах 607,6 сая төгрөгийн 24, хариуцлага тооцуулах 9, нийт 35 албан шаардлага өгч ажиллаа.

### 9.1 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид болон түүний харьяа байгууллагадын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар

№	“Хязгаарлалттай” дүгнэлт авсан байгууллага	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Баян–Уул сумын цэцэрлэг	Үндсэн хөрөнгийг жилийн эцсийн тооллого хийгээгүй, Урсгал засварын зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн, ажиллагсдын цалинг бэлнээр олгосон зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2	Аймгийн ИТХ	Үндсэн хөрөнгийг жилийн эцсийн тооллого хийгээгүй, Бараа материалын тайлан гаргаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна
№	“Санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан” авсан байгууллага	“Санал, дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал, дүгнэлтийн шалтгаан
	Баяндун сумын сангууд	Баяндун сумын Засаг даргын нөөц сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн тайлан хуулийн заасан хугацаанд тайланг хариуцсан аудиторт хүлээлгэж өгөөгүй тул дүгнэлт өгөхөөс татгалзсан болно.

